

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
НЭГДҮГЭЭР ХЭЛТСИЙН 2019 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.09.24

Улаанбаатар хот

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр**

**1.1 Төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр:**

***-Хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэр, бодлогын болон захиргааны үйл ажиллагааны баримт бичгийн зүйл, заалтын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан ажлын талаар***

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, Нийслэлийн цагдаагийн газраас 2019 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу 118 биелэлт тооцохоос 2019 оны гуравдугаар улирлын байдлаар бодлогын баримт бичиг 2, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн баримт бичиг 1, захиргааны байгууллагын үйл ажиллагааны баримт бичиг 1, шийдвэрийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бусад 12, нийт 56 баримт бичгийн биелэлт, үр дүнг нэгтгэн тооцож, тогтоосон хугацаанд Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

***-Байгууллагын даргын зөвлөлийн хуралдааны талаарх мэдээлэл, тушаалын тоо, шийдвэрлэсэн асуудлын талаар***

Хэлтсийн даргын дэргэдэх зөвлөл 2019 оны 3 дугаар улиралд 3 удаа хуралдаж 14 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, удирдлага, зохион байгуулалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын чиглэлээр “А” тушаал 2, захиргаа, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр “Б” тушаал 15, нийт 17 тушаал гарган хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж байна.

***-Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгавар, ажлын чиглэл, зааварчлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажлын үр дүнг тодорхойлж, товч тайлагнах.***

ЦЕГ-ын дарга, Тэргүүн дэд дарга нарын баталсан 14 төлөвлөгөө, 7 хөтөлбөр, 25 ажлын үүрэг, чиглэл, ЦЕГ-ын Дэд бөгөөд НЦГ-ын даргын өгсөн үүрэг 12, үүрэг, ажлын чиглэл 12, зөвлөмжийг хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар биелэлт, үр дүнг тооцох үүрэг, ажлын чиглэлийн биелэлтийг, холбогдох алба, нэгжүүдэд тогтоосон хугацаанд тайлагнасан.

Тухайлбал: Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаварын биелэлт, Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төвлөгөөний биелэлт нэгтгэн дүгнэж, холбогдох алба, нэгж рүү хүргүүлсэн.

***-Дээд шатны байгууллагаас ирүүлж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, санамж бичиг болон бусад эрх зүйн актад хүргүүлсэн санал, шинээр батлагдсан эрх зүйн актуудыг дагаж мөрдөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар***

Тайлангийн хугацаанд дээд шатны байгууллагаас ирүүлж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, санамж бичиг болон бусад эрх зүйн актын 4 төсөлд 7 санал, Хүргүүлсэн саналаас дурьдвал:

а. Сайжруулсан түлшээр хангахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар саналд 2 санал,

б. "Ойн тухай хууль тогтоомжийн зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгох журам"-ын төсөл төсөлд 1 саналыг албан бичгээр НЦГ-ын ТЗБХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн.

в. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд 3 санал,

**-Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, холбоо мэдээллийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаар товч тайлагнах**

#### **а.Архив, албан хэрэг хөтлөлт**

Ажлын хэсэг архивт хадгалагдаж байгаа хадгаламжийн нэгжийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, архивын ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 605,000 төгрөгний үнэ бүхий 3 ширхэг төмөр тавиур худалдан авч, дотоод нөөц бололцоог ашиглан архивын өрөөг засаж тохижуулсан.

2015-2017 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл болон устгах хэргийн актыг Цагдаагийн Ерөнхий Газрын БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан. 2018 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, устгах хэргийн актыг үйлдэн 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 25и/4792 дугаартай албан бичгээр Төв архивт хүргүүлсэн.

2015-2018 оны цаасан суурьтай байнга хадгалах Захирамжлалын 30 боть 3909 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, 2007-2018 оны 2680 боть баримтаас 1994-2018 оны 70 жил хадгалах 123 боть 27396 хуудас, 2016-2018 оны байнга хадгалах 160 боть 22780 хуудас, түр хадгалах 2397 боть 572691 хуудас, нийт 622867 хуудас баримтыг бүртгэлжүүлэн тоолсон.

Баримтуудыг цэгцэлж, дахин шинээр зөв байрлал, дараалалд оруулж тавиурт байрлуулан он цагийн заагуур хийж архивын баримтуудыг нягтлан шалгаж сэлбэн засах шаардлагатай 1994-2003 оны 73 боть санхүүгийн баримтаас цалингийн картыг ялган 19 боть цалингийн картыг сэлбэн зассан.

Байгууллагын архивт хадгалагдаж байгаа баримт бүрийг нягтлан шалгаж, хадгалах хугацаагаар ангилан /байнга, түр, 70 жил, устгах/ төрөлжүүлж, данс бүртгэл үйлдсэн. Мөн хадгалагдаж байгаа баримтын 95 хувийг хамгаалалтын хайрцагтай болгосон.

Архивын ерөнхий газраас гаргасан маягтын дагуу архивын баримтын ашиглалтын бүртгэлийг хөтөлж, баримт ашиглалтын хуудсыг бөглөж хэвшсэн.

Байгууллагын баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу боловсруулж, захирамжлал болон зохион байгуулалтын баримт бичгийн хавсаргалтыг хавсарган үүсэн баримтыг цахим болон цаасан хэлбэрээр хэрэг бүрдүүлэн хадгалж ажилласан.

#### **б.Холбоо, мэдээллийн чиглэлээр**

Улсын баяр наадам, ОХУ-ын ерөнхийлөгчийн айлчлал болон бусад нэгдсэн арга хэмжээний үеэр хэлтсийн алба хаагчдыг хэт богино долгионы радио станцаар ханган, холбоо зохион байгуулж ажилласан.

ЦЕГазрын даргын тушаалаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар байгуулагдаж тус хэлтсийн 2 дугаар байранд байрших болсонтой холбогдуулан газрын болон хэлтсийн алба хаагчдын сүлжээний монтажийн ажлыг шинээр хийж, гүйцэтгэн хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Тус хэлтсийн 2 дугаар байрны 3 давхрын шатны коридорын хэсэгт байрлах сүлжээний зогсуурыг буулган авч сүлжээний төхөөрөмжийг төмөр хайрцганд хийн хэвийн үйл ажиллагаанд оруулсан.

Хэлтсийн болон газрын шинээр томилогдсон алба хаагчдын компьютерт хэрэглээний програм хангамж суулгах, цагдаагийн байгууллагын дотоод цахим шуудангийн хаяг шинээр нээлгэх, нууц үг дахин сэргээлгэх, Абле програм хангамж болон цагдаагийн байгууллагын

мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрх шинээр үүсгэх, эрхийг өөрчлөх зэрэг хүсэлтүүдийг ЦЕГазрын МТХТөвд хүргүүлж шийдвэрлүүлсэн.

**-Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл, боломжийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар**

Хамт олны шийдвэр, сайн дурын үндсэн дээр 2 алба хаагчид гэр, хашаа, газар, урьд ажиллаж байгаад нас барсан 1 алба хаагчийн гэр бүлд 1 удаагийн буцалтгүй 1,000,000 төгрөг ба нийт 5,300,000 төгрөгийг хандивласан.

**-Нийслэлийн цагдаагийн газрын тайланд зайлшгүй тусгуулах өөрийн байгууллагын хүрээнд болон бусад байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн шинэлэг ажил, арга хэмжээний талаар**

Тус хэлтсийн мөрдөн байцаах тасгаас санаачлан сарын ажлаараа тасаг хамт олноо хошуучлан ажилласан алба хаагчийг ажлын үр дүнгээр нь цалинг нэмэхийн зэрэгцээ тасгийн дотоод нөөц бололцоо /хуримтлал/-нд тулгуурлан урамшуулж байх зохион байгуулалтын арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд сар бүр тасгийн сарын ажлын тайланг хэлэлцэн эдгээр саруудад хамт олноо хошуучлан ажиллаж хамгийн олон хэрэг шийдвэрлэсэн мөрдөгчийг гэр бүлийн гишүүний хамт кино театруудад саяхан нээлтээ хийж шинээр гарч байгаа уран сайхны кино, “Шинэ үе” продакшны шинэ уран бүтээлийн тоглолтыг үзэх эрхийн бичиг, өөрийн хариуцсан баг хамт олноо сайн зохион байгуулж, хамгийн олон хэрэг яллагдагчаар татаж шийдвэрлэсэн багт ус цэвэршүүлэгч, бичгийн цаас, бичгийн хэрэглэл зэргээр урамшуулсан нь алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээж, ажлын төлөө өрсөлдөх боломж нөхцөлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болон ба дээрх арга хэмжээг зохион байгуулснаар тус хэлтсийн Мөрдөн байцаах тасаг нь эхний хагас жилд Мөрдөн байцаах албаны 2019 оны хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтийн 7 заалтыг хангах биелүүлж, албан хэмжээнд тэргүүн байр, сахилга зүйн зөрчил дутагдалгүй хамт олон, цахим шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн хамт олон өргөмжлөлөөр шагнуулсан. 2019 оны 07, 08 сарын шийдвэрлэсэн хэргийн үзүүлэлтээр тэргүүн байранд явж байна.

Дээрх ажил, арга хэмжээг зохион байгуулсанаар 2019 оны 3 дугаар улиралд гэмт хэрэг 1529 хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 682 нэгжээр буюу 30 хувиар, үүнээс хулгайлах төрлийн гэмт хэрэг 575 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 364 нэгж буюу -38,8 хувь, 9 хувиар өссөн байна.

**1.2 Хүний нөөцийн чиглэлээр:**

**-Алба хаагчдын дунд зохион байгуулсан сургалт, түүний үр дүнгийн талаар**

Тус хэлтсээс “Албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу ажлын байран дахь сургалт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан 21 сургалтад давхардсан тоогоор 3156 алба хаагч хамрагдаж “E surgalt” санд мэдээллийг оруулсан. Зохион байгуулсан ажлуудаас дурьдвал:

Хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах сургалт, мэдээллийн лабораторийн үйл ажиллагаатай танилцуулж, мэдээллийн аюулгүй байдал, компьютерийн нууц үг солих, мэдээллийг хэрхэн хадгалах талаар “Тарваган тахлаас урьдчилан сэргийлэх” Цагдаагийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 29 дугаар зүйл, Осол гэмтлийн үед анхан шатны тусламж үзүүлэх /ЦБҮАЖ-код 209/, Бичиг баримт үзэж шалгах /ЦБҮАЖ-код 214/, Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох /ЦБҮАЖ-код 222/, Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх /ЦБҮАЖ-код 223/, Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон гадаадын иргэнтэй харилцах /ЦБҮАЖ-код 232/, Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх /ЦБҮАЖ-код 234/, Албадан эрүүлжүүлэх /ЦБҮАЖ-код

629/, Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх хуудас зэрэг нийт 10 хичээлтэй сургалтын видеог алба хаагчдад үзүүлж, дадлага сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм өөрчлөн батлагдсантай холбогдуулж “Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм”, “Цагдаагийн хүрээний дүрэм”, “Эргүүл, харуулын дүрэм”-ээр 3 цагийн сургалт зохион байгуулсан.

***-Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар***

Тус хэлтсээс алба хаагчдын чөлөөт зөв боловсон өнгөрүүлэх, цагийг гэр бүлийн гишүүдийн хамт хөгжилтэй өнгөрүүлэх, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах болон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ -ын 940.2.1-д заасны дагуу нийт бие бүрэлдэхүүний дунд соёлын үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг гаргаж батлуулан 2019 оны 3 дугаар улиралд 21 ажил арга хэмжээнд 4767 алба хаагчийг хамруулсан.

“Хэлтсийн 2019 оны соён гэгээрүүлэх, спорт, урлагийн тэмцээн уралдаан зохион байгуулах ажлын салбар төлөвлөгөө”-ний 19 ажил, арга хэмжээний биелэлтийг энэ оны эхний 9 сарын байдлаар гаргаж 89 оноотой 4,4 хувьтай дүгнэж, холбогдох газарт хүргүүлсэн.

Тухайлбал: Цагдаагийн байгууллагын болон Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн түүхэн замнал, компьютер дээр суурилсан мэдээллийн систем, програм хангамж болон програм хангамжийг хэрэглэн мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон хүлээн авах, унадаг дугуй ба эрүүл мэнд зэрэг сэдвээр **нийт 7 удаагийн 7 цагийн сургалт**, мэдээлэл тус тус явуулж давхардсан тоогоор 1080 **алба хаагч** хамрагдсан байна.

Тус цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах, хэрэг бүртгэх тасгийн алба хаагчдыг сургуулийн музей, Мөрдөх албаны тэнхим, Гадаад хэлний тэнхим, Албаны тусгай бэлтгэлийн тэнхим, шинээр байгуулагдсан Хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах сургалт, мэдээллийн лабораторийн үйл ажиллагаатай танилцуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв болон дээд шатны байгууллагаас 2019 оны 3 дугаар улиралд зохион байгуулсан 4 сургалтад давхардсан тоогоор 13 алба хаагч сургалтад хамрагдаж цагдаагийн байгууллагын “E surgalt” цахим санд бүртгэгдсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудын 2019 оны аварга шалгаруулах “Хөл бөмбөг”-ийн тэмцээнд амжилттай оролцсон.

***-Хүний нөөцийн бодлогын талаар /томилогдсон, чөлөөлөгдсөн, хүний нөөцийн нөхөн хангалт хийсэн батлагдсан орон тоо, дутуу орон тоо***

ЦЕГ-ын даргын 2019 оны А/78 тушаалаар 5 дугаар хороо шилжиж ирсэнтэй холбоотойгоор 103 офицер, 91 ахлагч, 9 энгийн ажилтантай нийт 203 алба хаагчтайгаар шинэчлэгдэн батлагдаж, одоогийн байдлаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч 1, 14 дүгээр хороо дахь цагдаагийн тасгийн ахлах байцаагч 1, телекамерын жижүүрийн цагдаа 1, эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаа 2, эргүүлийн цагдаа жолооч 1, эргүүлийн цагдаа 2, 16 дугаар хороолол дахь цагдаагийн хэсгийн чиглэлийн ахлах ажилтан 1, хороо хариуцсан цагдаа 2, жижүүрийн цагдаа 1 нийт 13 дутуу байгаа нь орон тооны нөхөн хангалт **93.2** хувьтай хүний нөөцийн талаар тогтвортой байна.

Шинээр томилогдсон 5 алба хаагчдад хэлтсийн даргын 2019 оны Б/41, Б/52 тушаалаар 5 сургагч багш томилуулж, алба хаагчийг богино хугацаанд албанд дадлагажиж мэргэших сургагч багшийн хөтлөх баримт бичгийн маягт, загварыг боловсруулж, ажлын хавтас хийлгүүлсэн.

## ***-Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар***

Биелэлтийн хугацаанд авлига, хээл хахууль авах, өгөх, зуучлах, шан харамж авсан зэрэг болон харъяаллын бус хэрэг маргаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдох зэрэг ёс зүйн зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, холбогдсон алба хаагч байхгүй болно.

Тус хэлтсээс Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг дэх үе шатны төлөвлөгөө /2017-2019 он/-г хэрэгжүүлж, 2019 оны эхний хагас жилийн биелэлтийг 10 бүлэг 33 заалтыг 98 хувьтай үр дүнг тооцож, Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Зохион байгуулсан ажлуудаас дурьвал:

а.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар мэдээллийн 3 самбарыг хэлтсийн хүлээлгийн танхим, олон нийт ихээр орж гардаг коридорт байрлуулсан сурталчилсан.

б.Авилгын эсрэг сургалтыг зохион байгуулахаар албан бичгийг 2019 оны 09 дүгээр сард Авлигатэй тэмцэх газрын олон нийтийн төвд хүргүүлсэн.

### **1.2 Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр**

#### ***-Хариуцсан нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөө, хөрөнгө зарцуулалт, үр дүнгийн талаар***

Иргэний зөвлөлөөс иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хууль, зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн санал, зөвлөмж ирүүлээгүй.

Дүүргийн ГХУСАЗСЗ-өөс эрүүлжүүлэх саатуулах байрны тохижилт, хана таашанд зөөвлөвч хийх, тусгаарлах өрөөний сандалыг бүрэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээллийг түгээх зорилготой 5 ширхэг телевизор зэрэг нийт 1,527,000 төгрөг зардлыг шийдвэрлүүлж, холбогдох бэлтгэлийг хангаж байна.

Мөн 50 ширхэг энгэрийн камерын төсвийг шийдвэрлүүлэхээр албан бичгийг хүргүүлсэн.

#### ***-Шилэн дансны хууль Засгийн газрын 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар:***

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хавсралтаар баталсан маягтын дагуу шилэн дансны цахим хуудсанд 42 мэдээ мэдээлэл, байгууллагын цахим хуудас <http://bayanzurkh-1.police.gov.mn/-d22> мэдээ мэдээлэл тус тус байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган хугацаа хоцроосон мэдээ байхгүй ажилласан.

Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулахад санаачлагатай ажиллан бичгийн цаас, хувилагч, олшруулагч машины ашиглалтанд хяналт тавьж, байгууллагын холбоо, цахилгаан, усны үргүй зардлыг багасгах талаар анхаарч төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого барьсан.

Төсвийн гүйцэтгэлийн 3 дугаар улирлын сарын мэдээ, 9 дүгээр хавсралтын дагуу цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн шивж мэдээлсэн.

2019 онд хийгдсэн түншлэлийн гэрээ, мөн худалдах худалдан авах тухай гэрээг шинэчлэн хийгээгүй тул мэдээлээгүй.

### **1.4 Сахилга хариуцлага, дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын чиглэлээр**

#### ***-Алба хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар***

Сүүлийн гурван жил буюу 2017, 2018 он 2019 ны эхний 9 сарын байдлаар бүртгэгдсэн сахилгын зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж, бууруулах, таслан зогсоох чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

а. 2019 оны 1, 2 дугаар улирлын сахилгын зөвлөгөөнийг 03 дугаар 29, 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, давхардсан тоогоор 274 алба хаагч оролцож дараах саналыг гаргасан. Зөвлөгөөнүүдээс 7 санал, санаачилгыг гаргаж, хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ авч ажилласнаар эхний 9 сарын байдлаар сахилгын зөрчил **20 нэгжээр** буюу **-69.8 хувиар буурсан** үзүүлэлттэй байна. 2019 оны 3 дугаар улирлын сахилгын зөвлөгөөнийг 09 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Энэ оны 3 дугаар улиралд 3-аас дээш удаа ажлаас хоцорсон, тасалсан, 2-оос дээш удаа сарын үндсэн цалинг бууруулсан, зөрчил дутагдал гаргасан, прокурорын “Шаардлага” болон албан бичигт нэр дурьдагдсан давхардсан тоогоор 36 зөрчилд 36 алба хаагчид “Сануулах хуудас” өгч бичгээр “Баталгаа” гаргуулсан.

2019 оны 3 дугаар улиралд Баянзүрх дүүргийн Прокурорын газраас “Прокурорын шаардлага” 1-ийг авч, шаардлагад 1 алба хаагч зөрчил заагдсан.

Ахлах мөрдөгч нараар алба хаагчдын анхаарвал зохих тодорхой сэдвээр Эрүүгийн цагдаагийн тасаг, Мөрдөн байцаах тасаг, хэрэг бүртгэх тасаг, НХЖХ тасгийн алба хаагч сургалт зохион байгуулсан.

Алба хаагчдад хэргийн хугацаа, прокурорын даалгавар, хэрэгт хийх ажиллагааны чиглэлээр зааварчилгаа хүргүүлэн, баталгааг авч, бүртгэлээр хяналт тавих ажлыг сайжруулан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Прокурорын шаардлага”-ын тоо -3 нэгжээр буюу -75 хувиар, шаардлагад зөрчил заагдсан алба хаагч -18 нэгжээр -94 хувиар тус тус буурсан.

***-Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар***

2019 оны 3 дугаар улиралд иргэд, байгууллагаас хэлтсийн удирдлагад хандан Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төв, ub1200.mn цахим хуудас, 1800-1200 тусгай дугаарын утас, check my service аппликейшнээр алба хаагчтай холбоотой 5 гомдол мэдээлэл хүлээн авч шалгахад алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй 4, ажиллагаанд 1 шалгагдаж байна.

***-Эрүүл ажлын байрны орчинг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар.***

Тус хэлтсээс байгууллагынхаа 1,2,3 дугаар давхарын коридорын ханыг будах, таазыг угаадаг шинэ хавтангаар солих, мэдүүлэг авах өрөөнүүдийг дуу тусгаарлах зориулалтай зөөлөвч материалаар бүрэх, алба хаагчдын өрөөний хаягийг шинэчлэн хийлгэх, жижүүрийн шуурхай албаны өрөөг засварлах, тавилаг эд зүйсийг шинэчлэх, зэрэг нийт 6,000,000 төгрөгний урсгал засвар хийж, эрүүлжүүлэх саатуулах байранд 5 телевизорын төсвийг шийдвэрлүүлэн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж ажилласан.

***Дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус зөвлөлийн ажлыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар***

Тус хэлтсийн эрсдлийн үнэлгээг тодорхойлох ажлын хэсгийг хэлтсийн даргын 2018 оны А/51 дугаартай тушаалаар шинэчлэн байгуулж, ажлын хэсгийг мэргэжлийн удирдлагаар хангаж, байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдлийг тодорхойлж, эрсдлийн давтамж, цар хүрээг шинжлэн судалж, ажилласан.

2019 оны “Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г батлуулж, биелэлт эхний хагас жилийн байдлаар 83.8 оноотой 4.1 хувьтай дүгнэгдэж, 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 25и/3269 дугаартай албан бичгээр Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

-Хэлтсийн даргын “Байгууллагын дотоод аюулгүй байдлын ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ажлын хэсгийг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар ахлуулсан 8 албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хавсралтаар ажлын хэсгийн гишүүдийн аюулгүй байдлын чиглэл хариуцах хуваарийг тус тус батлан мөрдөж байна.

Тушаалын 2 дугаар хавсралтаар хүний нөөц, алба хаагч, мэдээлэл, холбооны, санхүү, төсөв, галт зэвсэг тусгай хэрэгсэл, барилга байгууламжын аюулгүй байдал, эрсдлийг тодорхойлж, хариу арга хэмжээ авч ажиллах талаар тусгасан. Зохион байгуулсан ажлуудаас дурьдвал:

а. Алба хаагчдын эрүүл мэндийг хангах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх яриа таниулгыг 1 удаа зохион байгуулж, 49 алба хаагчийг тарваган тахлын вакцинд хамруулсан.

б. Хэлтсийн албаны авто машин, тоноглол, дагалдах хэрэгсэлд үзлэг шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор жижүүрийн 2, хэв журмын 6 авто машинд засвар үйлчилгээг хийлгэж ажилласан. Хэлтсийн даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/18 дугаар “Байгууллагын дотоод аюулгүй байдлын ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ажлын хэсгийг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар ахлуулсан 8 албан тушаалтаны бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хавсралтаар ажлын хэсгийн гишүүдийн аюулгүй байдлын чиглэл хариуцах хуваарийг тус тус батлан мөрдөж байна.

## **Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр**

### 2.1 Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд:

**-Тухайн дүүргийн хэмжээнд үйлдэгдсэн зөрчлийн мэдээ, хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч зохион байгуулсан ажил арга хэмжээний үр дүн болон цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар**

2019 оны 03 дугаар улирлын байдлаар Зөрчлийн тухай хуулиар 2167 иргэнийг 59.495.000 төгрөгөөр торгож, 8 аж ахуйн нэгж байгууллагыг 3.100.000 төгрөгөөр торгож, 2773 сэжигтэй иргэн, 648 тээврийн хэрэгсэл, 515 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж, ар гэртээ болон гудамж талбай олон нийтийн газарт согтуугаар агсам тавьж танхайрсан 2906 иргэнийг тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байранд хүлээлгэн өгч, 1670 хүнээс 6.762.250 төгрөгний төлбөр төлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон ахуйн хүрээнд согтуугаар агсам тавьж танхайрсан 127 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар шүүхээр баривчлуулж, архинд донтох өвчтэй 8 иргэнийг архины албадан эмчилгээнд явуулан ажилласан.

Дээрх ажил, арга хэмжээг зохион явуулснаар 2019 оны эхний 8 сарын байдлаар **1529 гэмт хэрэг** бүртгэгдсэнийг урд оны мөн үетэй харьцуулахад 682 буюу **-30.8 хувиар буурч**, үүнээс хулгайлах төрлийн гэмт хэрэг энэ онд 575 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 364 нэгж буюу **-38.8 хувь**, дээрэм 59 бүртгэгдсэн нь урд оныхоос **-65 нэгжээр буюу -52.4 хувиар** тус тус буурсан, 374 иргэнийг шүүхээр баривчлуулж, нийт 207300.0 мянган төгрөгний торгууль оногдуулсан үзүүлэлттэй байна.

**Камер техникийн хяналтын үйл ажиллагааны талаар /гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх зорилгоор теле камерын ашиглалтыг дээшлүүлэх, өргөжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, үр дүнг тооцсон байдал, нутгийн захиргааны байгууллагаар төсөв хөрөнгө, шийдвэрлүүлэхээр хамтран ажилласан байдал/**

2019 оны 03 дугаар улиралд телекамерийн 4 алба хаагч 78 удаа 24 цагаар нийт 2016 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, Баянзүрх дүүргийн 1, 3 дугаар хэлтсийн нийт 56 камераас нэгдүгээр хэлтсийн 24, гуравдугаар хэлтсийн 11 камер ажиллаж байна.

Ажиллагаанд байгаа 35 камерт давхардсан тоогоор 3800 гаруй удаа хөдөлгөөнийг хянаж, камерыг сэжиг бүхий объектууд руу харуулж, байршуулан зохих хяналтыг тавьж ажилласан.

2019 оны эхний 9 сарын байдлаар нийт 64 удаа холбогдох албан тушаалтны зөвшөөрлөөр 52 цагийн бичлэг шүүлгүүлж, 18 зөрчлийг холбогдох албан хаагчдад

мэдэгдэж, торгуулийн арга хэмжээ авхуулсан. Мөн эргүүлд явж байгаа алба хаагчдыг чиглэл дээрээ хэрхэн ажиллаж байгааг камераар хянасан.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан “2019 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөн”-д Баянзүрх дүүргийн 4, 5, 14 дүгээр хороодын гудамж зам талбайн камержуулалтын 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгасан.

***Хэсгийн байцаагчийн ажил үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар / хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн/***

а. Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд хэсгийн байцаагчийн захиргааны үүргийн хүрээнд хариуцсан хорооны нутаг дэвсгэрт байрлах субъект /ахисан дүнгээр/ 2102, объект 320, нийт 2424 судаалгаа, мэдээ, мэдээллийг санд оруулсан.

б. Хороо хариуцсан 9 хэсгийн байцаагчийн ажлыг шалган зааварчилж, хэсгийн байцаагч нараас “Захиргааны туслах тоо бүртгэл” мэдээллийн системд оруулж байгаа мэдээлэлд тухай бүр хяналт тавьж, санал хүсэлтийг нь авч ажилласан.

в. Хороо хариуцсан хэсгийн байцаагч нарын ачаалалыг тэнцвэржүүлэх зорилгоор хоногийн хэрэг бүртгэгчээр эргүүлийн офицеруудыг ажиллуулж, хэсгийн байцаагч нарыг хариуцсан хороондоо гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд ойр ажиллах нөхцөлөөр хангасан.

г. Тайлангийн хугацаанд гэр бүл хүчирхийлэл удаа дараа үйлдсэн 18 этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар эрх бүхий албан тушаалтанд харъяаллаар шилжүүлж, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд зааснаар 7-30 хоногийн хугацаатайгаар 127 иргэнийг, Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлд зааснаар 7-30 хоногийн хугацаатайгаар 11 иргэнийг тус тус шүүхээр баривчлуулан, нийт 141 иргэнийг шүүхээр баривчлуулсан нь урд оны мөн үетэй харьцуулахад 10 нэгж буюу 6,6 хувиар буурсан, нийт 60,585,000 мянган төгрөгний торгууль оногдуулсан нь өмнөх оноос 17,540,000 төгрөгөөр буюу 40,7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

д. “Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг гомдлыг шалгахад анхаарах асуудал, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирогч нараас мэдүүлэг авахад зайлшгүй авах асуултууд, албан хэрэгцээнд ашиглах зөрчлийн хэргийн загвар”-ыг гарын авлага болгон албан бичгээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Шуурхай удирдлагын тасагт хүлээлгэн өгсөн.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг зөрчлийг хүлээн авах, зөрчил гаргасан этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, дуудлага, мэдээллийг материалжуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиглэлээр хоногийн хугацаанд ерөнхий эргүүл, тасгийн дарга нар хяналт тавин ажилласан.

Биелэлтийн хугацаанд гэр бүл хүчирхийлэл үйлдсэн 18 этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд зааснаар 7-30 хоногийн хугацаатайгаар 127 иргэнийг шүүхээр баривчлуулсан нь мөн үетэй харьцуулахад 27 нэгжээр буюу 27 хувиар өссөн.

Дээрх ажил, арга хэмжээг зохион байгуулсанаар **гэр бүл хүчирхийллийн дуудлага мэдээлэл** 1374 буюу нийт дуудлагын 10,9 хувийг эзэлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 нэгжээр буюу **2.8** хувиар өссөн.

***Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар / хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт хийх, үр дүнг тооцох, Тухайлбал Эмзэг цэг тооцоо судалгааг тайлагнах/***

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/504 дүгээр захирамжийн хүрээнд хариуцсан хороодын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдан



борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор “Архигүй өдөр” тусгай арга хэмжээг сар бүрийн 01-ний өдрийн 00:00 цагаас 02-ны өдрийн 00:00 цагийн хооронд тус хэлтсийн хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 510 аж ахуйн нэгж байгууллагад Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 9 хэсгийн байцаагч, 9 хороо хариуцсан цагдаа, 6 олон нийтийн цагдаа, нийт 24 алба хаагчийг 3 удаа 72 хүн/цагийн үүрэг гүйцэтгүүлэн хяналт тавьж, нийт 5 иргэнийг 375.000 төгрөгөөр, 8 аж ахуйн нэгж байгууллагыг 4.000.000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан тухай танилцуулгыг тухай бүр НЦГ-т хүргүүлэн ажилласан.

МУ-ын “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, гудамж талбай олон нийтийн газарт нийгмийн дэг журмыг сахиулах, гудамж талбайд согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, багасгах зорилгоор нэгдсэн болон тусгай арга хэмжээнүүдийг 3 удаа зохион байгуулж, тухай бүр үр дүнг тооцон ажилласан ба хариуцсан нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр-үйлчилдэг 240 байгууллага, аж ахуйн нэгжүүдийн цагийн хуваарь, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэнд өдөр тутам хяналт тавьж, илэрсэн зөрчлүүдийг хуулийн дагуу шийдвэрлэж ажиллаж байна. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн заалт бүхий хэлтсийн даргын дугаартай 168 албадан мэдэгдэл өгч, 156 хариу авч, санамж сэрэмжлүүлэг 81, гарын авлага 75 ширхэг, зурагт хуудас 61 ширхэг, сэрэмжлүүлэг 247 ширхэгийг тараан хийсэн ажлаа 1 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажигласан.

Хариуцсан хороодын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг болон иргэдийн аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх талаар “Эмзэг цэг” арга хэмжээний хүрээнд өдөр бүр 2 алба хаагчийг ажиллуулж, хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан 17 иргэнийг 1.500.000 төгрөгөөр, 15 аж ахуйн нэгж байгууллагыг 4.200.000 төгрөгөөр тус тус торгуулийн арга хэмжээ авч, ажилласан байна.

Хууль зөрчин удаа дараа тавьсан шаардлага биелүүлээгүй архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 1 /“Хаанчлал” баар, зочид буудал, караоке/ аж ахуйн нэгжийн зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг Нийслэлийн захирагчийн албанд хүргүүлэн эрхийг түтгэлзүүлсэн.

Хууль зөрчин удаа дараа тавьсан шаардлага биелүүлээгүй архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 1 аж ахуйн нэгжийн зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг Нийслэлийн захирагчийн албанд хүргүүлсэн.

Согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг цэг салбарт мэдэгдэл өгч, хяналтыг сайжруулснаар **согтуугаар** үйлдэгдсэн гэмт хэрэг **27** хувиар **гудамж талбайд** үйлдэгдсэн гэмт хэрэг **23,6** хувиар тус тус **буурсан** үзүүлэлттэй байна.

### ***Эргүүлийн үйл ажиллагааны талаар зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар***

Тус хэлтсийн хариуцсан хороодын нутаг дэвсгэрийн эрүү хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд 9 хэсгийн байцаагч, 9 хороо хариуцсан цагдаа, 7 олон нийтийн цагдаа, 12 урамшилт эргүүл, авто эргүүлийн амарч байгаа ээлжийн 8, нийт 45 алба хаагчийг явган эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн ажиллуулсан бөгөөд 2019 оны 3 дугаар улиралд давхардсан тоогоор 66 удаа 2970 алба хаагч 17820 хүн/цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэрэг 31, гэмт хэргийг таслан зогсоосон 1, оршин суугаа газраасаа сураггүй алга болж эрэн сурвалжлагдаж байсан 43 этгээдийг олж тогтоож, зөрчил гаргасан иргэн, аж ахуй нэгж байгууллага 1121 зөрчлийг илрүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу 36.285.000 төгрөгөөр торгуулийн шийтгэл ногдуулж ажилласан.

### ***Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны талаар / олон нийтийн болон оюутан цагдаа, олон нийтийн цагдаагаас тухайн сард ажилласан үр дүнг тооцон тайлагнах/***

Тус хэлтэст олон нийтийн цагдаагийн 9 орон тоотойгоос 1 жирэмсний амралттай, хүсэлтээрээ 1 халагдаж, үүрэг гүйцэтгэж байгаа 7 байна.

Олон нийтийн цагдаа нарыг сургаж дадлагажуулах ажлыг тогтмол зохион байгуулж, хэлтсийн даргын тушаалаар хариуцсан хэсгийн байцаагч нартай сурган дадлагажуулах гэрээ

байгуулан сахилга, ёс зүйн зөрчил гаргахгүй байх, албаны бэлэн байдал хангаж ажиллах талаар үүрэг чиглэл өгч, баталгаа авч, хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү хэв журмын нөхцөл байдалд уялдуулан авто эргүүлийн алба хаагч болон олон нийтийн цагдаагийн ажилтны хамтарсан эргүүлийг өдрийн цагаар 8 цагийн хугацаагаар тогтмол зохион байгуулж, хэсгийн байцаагч болон цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын удирдлаган дор ажиллуулсан.

Тус хэлтсийн Олон нийтийн цагдаа нар нь энэ сард гэмт хэрэг зөрчлийн талаар Цагдаагийн байгууллагад болон холбогдох байгууллагад танилцуулсан 36, Нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдэд зохион байгуулж ажилд оролцсон 22, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, шалгалтыг хэсгийн байцаагч, хороон цагдаа, авто эргүүл, алба хаагч нарын хамт тогтмол зохион байгуулж ажилласан.

Хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн цагдаа нар нь тус бүр хариуцсан хорооны задгай гэх хаягтай, бүлэг бөөгнөрөл үүсгэдэг айл өрх, хороодын эмзэг цэгүүдийн шинэчилсэн судалгааг гаргаж тэдгээр цэгүүдэд тогтмол эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар айл өрхүүдээр давхардсан тоогоор 2125 иргэн, 1342 аж ахуй нэгж байгууллагад ухуулга яриа таниулга хийж, хамтарч ажилласан болно.

2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт урамшилт эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг 19 иргэнд орон байрны хулгай, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг иргэдэд хэрхэн хүргэх талаар сургалт зохион байгуулж, зааварчилгаа бичиж өгсөн.

Сургуулийн орчимд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “School Police” сургуулийн эргүүл ажиллуулах, анхаарах асуудал, хамтын ажиллагааны талаар хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын 15 сургуульд зөвлөмж боловсруулан урамшилт эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг 19 иргэн, хүүхэд хамгаалагч нарт “Хичээлийн шинэ жил” нэдсэн арга хэмжээний хүрээнд хийх ажлын талаар сургалт хийж, зааварчлага бичиж өгсөн.

Урамшилт эргүүлийн үйл ажиллагааг сар бүр дүгнэж, урамшуулалд 2,380,000 төгрөгийг Нийслэлийн ЗДТГ-с олгосон.

***Захиргааны хяналтын үүргийн хэрэгжилтийн талаар /нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн бүртгэл тооллогод хяналт тавьж ажилласан талаар, галт зэвсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал/***

Галт зэвсэг тооллогод хамрагдаагүй 126 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хаяган дээрээ байхгүй 95, эзэмшигч нь нас барсан 12, өөр дүүрэг, хорооруу шилжсэн 68, галт зэвсгээ бусдад шилжүүлсэн 8 байгааг олж тогтоож, бүртгэлд хамруулах чиглэлээр эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулан ажилласан бөгөөд 2019 оны эхний хагас жилд эзэмшигч нь нас барсан 1, бүртгэлгүй 1, нийт 2 ширхэг галт зэвсгийг хураан авч албан бичгээр Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг хаягаар алба хаагчдыг нэг бүрчлэн явуулж, мэдэгдэлөгч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 15 удаа иргэд, олон нийтэд мэдээлэл хүргүүлж, 1285 ширхэг санамж, сэрэмжлүүлэг тараасан.

***Гэрээт харуул хамгаалалтын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах журмын биелэлтэд хяналт тавих ажлын талаар /нутаг дэвсгэрийн хэмжээнд гэрээт харуул хамгаалалтын байгууллагыг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж ажиллуулсан байдал, үр дүн/***

Цагдаагийн ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн За/3684 тоот албан бичгээр ирүүлсэн “Гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас хяналт тавих үйл ажиллагаа”-нд хийсэн дотоод аудитын тайлан, зөвлөмжийн дагуу өгсөн ажлын чиглэлийг дараахь байдлаар хэрэгжүүлэн ажиллаа.

Үүнд:

Тус хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасгаас дээрх ажлын чиглэлийг 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 08 дугаар сарын 22-ны өдрүүдэд хэрэгжүүлэн ажиллах

төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь гарган батлуулж, 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдөр тасгийн 72 алба хаагчид танилцуулсан.

Цахим сангийн зөвхөн баталгаажсан төлөвт шилжсэн хуулийн этгээдүүдээс бусад төлөвт байгаа гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын судалгааг 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдөр гаргасан.

Тус хэлтсийн хариуцсан хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 25 гэрээт харуул хамгаалалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ын хэрэгжилт, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10.1-дэх заалт /Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг цагдаагийн төв байгууллага хариуцна./-ын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллахад зөрчил дутагдал илрээгүй болно.

***Хуульд заасан захиргааны бусад хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлыг товч тайлагнах /цахим тоглоомын үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчил гаргасан этгээдэд торгуулийн арга хэмжээ авсан байдал***

“Эмзэг цэг хяналт-шалгалт” арга хэмжээний хүрээнд цахим тоглоомын газруудыг давхардсан тоогоор 42 удаа шалгаж Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг Мажор цахим тоглоомын газарт шөнийн цагаар насанд хүрээгүй хүнийг хонуулан тоглуулдаг гэх 1 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 15.2.1-т зааснаар 250.000 төгрөгний торгууль ногдуулсан.

Нийслэлийн цагдаагийн газар, Нийслэлийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газрын хамтарсан “Цахим тоглоом” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 410 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2019 оны 05 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн, дүүргийн онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн, Хүүхэд, гэр бүл хөгжлийн мэргэжилтэн, тус хэлтсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэйгээр хариуцсан хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 25 цахим тоглоомын газарт хяналт шалгалт хийж, хууль тогтоомж, стандартын шаардлага хангаагүй, насанд хүрээгүй хүүхдэд үйлчилсэн зэрэг зөрчлүүдийг илрүүлэн 6 иргэнийг 1.800.000 төгрөгөөр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар цахим тоглоомын 4 газрын саналыг Нийслэлийн Харилцаа холбооны газарт хүргүүлсэн.

***Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан зэрэг гэнэтийн аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэм сахиулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар***

Байгалын гамшиг осол, газар хөдлөлтийн аюулын үед байгууллагын эд хөрөнгө, баримт сэлтийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэлтсийн төлөвлөгөөг 2019 оны 07 дугаар сард шинэчилэн алба хаагч нарт танилцуулж, гал гарсан, аюул осол гарсан үед хэлтсийн байрнаас гарах схем зураглал, хаягийн бүртгэл, түргэн цугларалтын схем зэргийг шинэчлэн хийж батлуулсан.

***-Нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтын чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:***

Баяр наадмын үеийн хэв журмын хамгаалалтын салбар төлөвлөгөө гарган ажиллаж биелэлтийг НЦГ-т хүргүүлсэн. Зохион байгуулсан ажлуудаас дурьдвал:

-Баяр, наадмын хамгаалалтын үед Цагдаагийн ерөнхий газрын А/167 цагдаа, дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэгт шилжүүлэн ажиллуулах тухай тушаал, хамгаалалтын төлөвлөгөөг танилцуулж нэгдсэн үүрэг чиглэл өгч, алба хаагч нэг бүрээр хуваарь, томилгоонд гарын үсэг зуруулан аюулгүй ажиллагааны зааварчилга өгсөн

-хамгаалалтанд 120 алба хаагч 8 удаа 1316 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

-Наадмын тасалбар борлуулах үеийн хамгаалалтанд 40 алба хаагч 24 цагийн үүргийг ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажилласан.

Хүй долоон худагт хурдан морьдын уралдааны хамгаалалтанд ажиллах 50 алба хаагчийг ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажилласан.

Мөн хамгаалалтын үед үүсч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг баримтжуулах дүрс бичлэгийн камер 1 ширхэг, фото аппарат 1 ширхэг нөөц батарей 2 ширхэг, хэргийн газрын хамгаалалтын тууз 2 ширхэг, олс 1 ширхэгийг бэлтгэн албаны бэлэн байдлыг хангаж 3 удаагийн хамгаалалтанд 36 алба хаагчаар 328 хүн/цагийн үүрэг гүйцэтгүүлэн хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

***-Эрүү хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар***

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг судлаж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд санал зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий “Судалгаа, дүн шинжилгээний баг”-ийг хэлтсийн даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/17 дугаар тушаалаар 9 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

-2017, 2018 онд гудамж, талбай олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгаан дээр үндэслэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Мэдэгдэл-Хяналт шалгалт” ерөнхий арга хэмжээний хүрээнд аж ахуй нэгж байгууллага, иргэдэд 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 05 дугаар сарын 21-ний хооронд мэдэгдэл өгч, мэдэгдлийн мөрөөр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл ажил зохион явуулж байгаа эсэхэд хяналт шалгалтыг үе шаттай зохион байгуулж ажиллаа.

Шалгалтаар: -Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг 87 аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж, мэдэгдлийн хариуг хугацаанд нь өгөөгүй, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй 17 аж ахуйн нэгж байгууллага, 11 иргэнд, мөн зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан 6 барьцаалан зээлдүүлэх газарт нийт 34 зөрчилд 31.100.000 төгрөг, диско баар, ресторан, паб, кафе зориулалтаар үйлчилгээ явуулдаг 142 аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж, 56 зөрчилд 24.550.000 төгрөгөөр тус тус торгууль оногдуулж ажилласан

Мөн нийтийн байрны зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 106 байрны үйл ажиллагааг шалгаж, түр оршин суудаг 1056 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргаж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэхийг шалгаж, эрэн сурвалжлагдаж байсан 4 сэжигтэй этгээдийг харьяа хэлтсүүдэд хүлээлгэн өгч тус тус ажилласан.ЦЕГ-ын тэргүүн дэд даргын 2018 оны А/11 дүгээр тушаалаар туршилтын журмаар тус хэлтсийн эрүүгийн мөрдөгч нарыг гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэх чиглэлээр 3 сарын хугацаатай туршилтын журмаар тус хэлтсийн эрүүгийн мөрдөгч нарыг гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэх чиглэлээр 3 сарын хугацаатай ажиллуулж, хэргийн баримтжуулалтын явцад 71 этгээдтэй хамтран гэмт хэрэг үйлддэг 191 сэжигтэй этгээдийг тогтоож, тэдгээрт чиглүүлэн 7 туслагч элсүүлэн хамтран ажиллаж, ач холбогдол бүхий 123 мэдээ авч нотлох баримт олж тогтоох, хууль бус үйлдлийг илрүүлэх зорилгоор ГА-ын 48 идэвхтэй арга хэмжээг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулж, 7 мөрдөн тагнах хэргийн 16 этгээдэд холбогдох 83 хэрэг, үйлдлийг илрүүлэн дайчилж хэргийг шийдвэрлэж ажилласанаар хэргийн илрүүлэлт эхний 5 сарын байдлаар урьд мөн үеэс +10 хувиар өссөн.

Дээрх ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласанаар гэмт хэргийн илрүүлэлт урьд оны мөн үеэс +10 хувиар өсч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25,5 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 47,9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хэлтсийн даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/08 “Орон тооны бус зөвлөл шинэчлэн байгуулах тухай” тушаалаар эрэн сурвалжлагдсан хүн, мал, эд зүйл, галт зэвсэг, сум хэрэгсэл, бодис, түүх соёлын дурсгалт болон үнэт зүйлийг олж тогтоох ажилд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр 6 гишүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

-Улсын хэмжээнд 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 19-ний өдрийн хооронд 14 хоногийн хугацаатай зохион явагдсан “Сураггүй алга болсон хүн-2019” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд арга хэмжээ эхлэх үед тус хэлтсийн хэмжээнд сураггүй алга болсон нийт 48 хүн бүртгэлтэй байсныг хариуцсан хороодын хэсгийн байцаагч, эрүүгийн мөрдөгч нарт хуваарилж, өмнө зарлагдсан 29, хойш зарлагдсан 6, нийт 35 хүнийг арга хэмжээний хүрээнд олж тогтоосон нь ажлын үр дүнгээр НЦГ-ын хэмжээнд тэргүүлсэн.

2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд улсын хэмжээнд зохион явагдсан “Тулгалт-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд сураггүй алга болсон 17 хүн, хэн болох нь тогтоогдоогүй 13 цогцос, гэмт хэрэгт сэрдэгдсэн 14 этгээд, нийт 44 эрэн сурвалжлалт зогсоосон нь Улсын хэмжээнд тэргүүлсэн.

-2019 оны эхний хагас жилийн байдлаар сураггүй алга болсон нийт 148 хүн зарлагдсанаас 148 хүнийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон. Одоо тус хэлтэст 16 хүн эрэн сурвалжлагдаж байгаагаас 15 хүн нь 1980 оноос 2013 оны хооронд алга болсноор эрэн сурвалжилж байна.

2019 оны эхний хагас жилийн байдлаар оргодол 6 зарлагдсанаас 3 оргодлыг, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 164 зарлагдсанаас 141 этгээдийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон. Хэлтсийн хэмжээнд 4 оргодол, 46 гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлагдаж байна.

-Галт зэвсэг эрэн сурвалжлах ажлын хүрээнд 2019 оны 01 дүгээр сарын байдлаар тус хэлтсийн хэмжээнд эрэн сурвалжлагдаж байсан 7 галт зэвсгийг тулгалт хийхэд 1 галт зэвсэг давхар эрэн сурвалжлагдсан байсныг тогтоож, эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Одоо тус хэлтсийн хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа 6 галт зэвсгийг олж тогтоохоор ажиллаж байна.

2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “АСАП” санд эрэн сурвалжлалт зарласан 36 тээврийн хэрэгслийг хэрэг, гомдол мэдээлэл бүртэй тулгалт хийж, 19 тээврийн хэрэгслийн эрэн сурвалжлалтыг зогсоосон, ба “Автомашин-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 8 тээврийн хэрэгслийг олж, эрэн сурвалжлалтыг зогсоож, одоо тус хэлтсийн хэмжээнд 9 тээврийн хэрэгсэл эрэн сурвалжлагдаж байна.

Эрэн сурвалжлалтын гүйцэтгэлийн хувийг 2019 оны нэгдүгээр улиралтай харьцуулахад гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 76.3 хувиас 86 хувь, тээврийн хэрэгсэл 42.8 хувиас 91.8 хувь, шүүхээс даалгасан бусад хүн 31.2 хувиас 61.6 хувь, эд зүйлс 2.2 хувиас 64.9 хувь, хэлтсийн нийт эрэн сурвалжлалтын гүйцэтгэл 35.7 хувиас 73.2 хувь болж өссөн эерэг үр дүнтэй байна. Хэлтсийн хэмжээнд 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар “АСАП” санд сураггүй алга болсон хүн 16, шүүхээс даалгасан бусад хүн 128, оргодол 4, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 46, хэн болох нь тогтоогдоогүй цогцос 61, тээврийн хэрэгсэл 9, галт зэвсэг 6, үнэт зүйл 1, мал амьтан 1, аман зургаар 30, эд зүйлс 3324 эрэн сурвалжлагдаж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт урьд оны мөн үеэс **+4.6 хувиар өсч, согтуугаар** үйлдэгдсэн гэмт хэрэг **27 хувиар, гудамж талбайд** үйлдэгдсэн гэмт хэрэг **23.6 хувиар** тус тус **өссөн үзүүлэлттэй** байна.

## **2.2 Урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

***Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой, бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамрагдаж байгаа болон бие даан хэрэгжүүлж байгаа төсөл, хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар***

- Тус хэлтсээс 2019 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар төлөвлөгөөг 3 дугаар сарын 1-ний өдөр батлуулж, гуравдугаар улирлын биелэлт 78,5 оноотой 3,8 хувьтай дүгнэгдэж, холбогдох нэгж рүү хүргүүлсэн.

-Биелэлтийн хугацаанд нэгдсэн 1, хэсэгчилсэн 3 арга хэмжээ, 4 үзлэг шалгалт, 7 сургалт, сурталчилгаа, 1 өдөрлөгт 3405 иргэн, 32 ААНБ хамрагдаж, 55 мэдэгдэл өгч 11 хариу авч, 28 шаардлага өгч, 28 хариуг авч ажилласан.

***Хөршийн хяналтын бүлэг, хэв журмын урамшилт эргүүл, хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоосон цагдаагийн байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад өгсөн “Мэдэгдэл”, “Шаардлага” түүний үр дүнгийн талаар:***

“Нийтийн эргүүл ажиллуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу тус хэлтсийн хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт 19 урамшилт эргүүл гудамж, талбай, олон нийтийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 540 хүн цагийн эргүүлд ажиллаж, 28 зөрчлийн талаар мэдээллийг хороо хариуцсан алба хаагчдад өгч ажилласан.

Урамшилт эргүүлийн үйл ажиллагааг сар бүр дүгнэж, 3 дугаар улиралд урамшуулалд 1,995,000 мянган төгрөгийг Нийслэлийн ЗДТГ-с олгосон.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд гудамж, талбай, олон нийтийн газар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн хяналтын бүлэг” 17-г байгуулан оршин суугаа хорооны нутаг дэвсгэрт 7 хоногийн 2 өдөр, 2 цагийн хугацаанд эргүүл хийн ажиллаж байна. Хөршийн хяналтын бүлгийн ажилласан тайланг сар бүр НЦУГ-т хүргүүлэн үр дүнг нь тооцон ажиллаж байна.

Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 4 иргэнд хэсгийн байцаагч нар хяналт тавин, хяналтын прокурорт хувийн хэргийг танилцуулан ажиллаж байна. Энэ хугацаанд гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй болно.

***Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн баталгаажилт, малын шилжилт хөдөлгөөнд урьдчилан сэргийлэх, хяналтын чиглэлээр хийсэн ажил арга хэмжээний талаар***

Нарантуул ОУХТ-ийн Баялаг ундраа төвд махны худалдаа эрхэлдэг 62 иргэн ажилладаг бөгөөд эдгээр иргэдийг судалгаанд авч, хууль эрх зүйн мэдээллийг цаг тухайд нь өгч ажиллаж байна. Уг махны тасагт сүүлийн үеийн IP камер 3 ширхэгийг суурилуулж, цагдаагийн алба хаагчид камерын бичлэгэнд хяналт тавин ажиллаж байна.

***Хүрээлэн байгаа орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил арга хэмжээний талаар***

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тайлангийн хугацаанд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн пэйж хуудсаар дамжуулан иргэдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, постер байршуулж ажилласан. Мөн 2019 оны 05 сарын 20-нд “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран 16 байгууллага, иргэнд ой хээрийн, объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 цагийн сургалтыг зохион байгуулж ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 9 сургууль, их дээд 5 сургуулийн оюутнуудад болон 750 орчим иргэдэд ой хээрийн гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн гарын авлага 750 ширхэгийг тарааж ажилласан. Мөн Дүүргийн ГХУСАЗСЗ-тэй хамтран “Байгаль ээжээ хайрлая” нэртэй хүүхдийн зурагтай номыг 900 ширхэгийг хэвлүүлж иргэдэд тараан сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр машинт эргүүлийн алба хаагчдад зааварчлага, үүрэг чиглэлийг өгч ажиллаж байна. Мөн Дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтарсан шалгалтыг томоохон зах худалдааны төвүүд, сургууль, цэцэрлэгүүдээр улирал тутам зохион байгуулан ажиллаж байна.

Харьяа нутаг дэвсгэрт мод, модон материалын үйлдвэр, худалдааны төв байхгүй бөгөөд 2019 оны 3-р улиралд хүрээлэн байгаль орчны эсрэг гэмт хэрэг тус хэлтэст бүртгэгдээгүй болно.

**Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй телевиз FM радио өдөр тутмын сонин сэтгүүл, сайтуудад хамтран ажиллах гэрээ байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах ажлын талаар**

Нэгдсэн арга хэмжээний үед ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын цахим хуудсанд байршуулсан 16 шторк, контентийг хэлтсийн цахим хуудас, угтах үйлчилгээний урсдаг Лед самбар, телевиз, 9 хорооны цахим хуудас, иргэдийг хүлээн авах хэсгийн ухаалаг дэлгэц болон олон дагагчтай 15-20 цахим хуудсанд мэдээллийг түгээн байршуулсан.

ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвтэй хамтарч 2019 оны 07 сарын 20-нд Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг гол усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл бэлтгэж 8 телевизээр иргэдэд түгээн ажиллаж байна.

“Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулж байгаа ажлын талаар болон “Хүүхэд хамгаалагч” танилцуулга өдөрлөгийн талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвд 2019 оны 09 сарын 17-ны өдөр мэдээ бэлтгэн иргэдэд хүргэн ажилласан.

Ахлах мөрдөгч цагдаагийн хошууч П.Алтанзул нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох болон холбогдохоос урьдчилан сэргийлэхтэй холбоотой ярилцалагыг ТВ5 телевизд 2019 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр өгсөн.

“Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Хүүхэд хамгаалагч” өдөрлөг, сургалтууд болон хяналт шалгалтын чиглэлээр хийж гүйцэтгэж байгаа ажил, арга хэмжээний талаар мэдээллийг 24 цаг. мн, Онцлох.мн, Шуурхай. Мн зэрэг 12 сайтад тухай бүрт нь мэдээллийг байршуулан, олон нийтэд түгээн ажиллаж байна.

**Монгол Улсад зорчиж буй гадаадын иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион явуулж үр дүнг тооцсон байдал**

Хэлтсийн хариуцсан 9 хороодын нутаг дэвсгэрт түр хугацаагаар оршин суудаг гадаадын иргэдийн бүртгэл судалгааг 2019 оны гуравдугаар улирлын байдлаар хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа нар нэг бүрчлэн тулгалт хийж, 15 иргэний судалгааг шинэчлэн цахим санд мэдээлэл оруулсан.

**Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн сүлжээ хуудас, байршуулж олон нийтэд хүргэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар**

“Баянзүрх дүүргийн иргэдийн нэгдсэн групп”, “Баянзүрх дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэс” пейж хуудсаар олон нийтэд мэдээлэл, видео шторк зэргийг хүргэж байгаа ба тус пейж хуудас 2700 дагагчтай, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга, нөлөөлөл, ажил, арга хэмжээний чиглэлээр эхний 9 сарын байдлаар нийт 100 мэдээлэл оруулж ажиллаж байна.

### **2.3 Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр**

**Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил арга хэмжээ, үр дүнгийн талаар**

Хэлтсийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Б/19 дүгээр “Хүүхэд хамгаалагч туршилтын төсөлд эргүүлээр ажиллах иргэнийг томилох тухай” тушаалаар тус хэлтсийн нэр бүхий 9 ахмад ажилтаныг төслийн зохицуулагчаар томилж, хариуцсан 9 хорооны нутаг дэвсгэрт хүүхэд хамгааллын чиглэлээр эргүүлийн үүргийг 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж байна.

“Хүүхэд хамгаалагч-ахмад мэргэжилтэн”-тэй хамтран ажиллах гэрээг мөн өдөр байгуулж, гэрээний дагуу Хөдөлмөр халамж үйлчилгээний байгууллагаас хөдөлмөрийн бүтээмжийг үнэлсэн урамшуулал, хөлсийг олгож ажиллахаар шийдвэрлэсэн.

“Хүүхэд хамгаалал” төслийн өдөрлөгийн нээлтийг 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Сүхбаатарын талбайд тус хэлтсийн хариуцсан хороодын ерөнхий боловсролын 9 сургуулийн 1-12 дугаар ангийн 11520 сурагч, 413 анги удирдсан багш, нийт 11993 багш, сурагчыг оролцуулж, холбогдох мэдээллээр хангаж, гарын авлага тараасан.

“Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд уулзалт, өдөрлөгийг 2019 оны 09 дүгээр сарын 17-18-ны өдөр Парк зочид буудалд зохион байгуулж, НЦУГ-ын Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, хороодын Засаг дарга, нийгмийн ажилтнууд, Их дээд, ерөнхий боловсролын сургуулиудын захирал, нийгмийн ажилтнууд, хороо хариуцсан хэсгийн байцаагч нар зэрэг 150 албаны төлөөлөл оролцлоо.

### ***Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар***

Зохион байгуулсан ажлуудаас дурьдвал:

а. 2019 оны 06 сарын 27-ны өдрөөс 07 сарын 05-ны хугацаанд “Илрүүлэлт-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд ажилласан. Арга хэмжээний хүрээнд хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлж байсан 18 хүүхдийг илрүүлж асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, насанд хүрээгүй хүмүүсээс эрхэлхийг хориглосон хөдөлмөрийн талаар сургалт зохион байгуулж ажилласан.

б. 2019 оны 07 сарын 10-12-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэн болон, наадмын талбайд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, эцэг, эхээсээ төөрсөн 6 хүүхдийг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласан.

в. “Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт байрлах их дээд 9, ерөнхий боловсролын 9 сургууль, 15 цэцэрлэгийн камерыг шалгаж, зөрчилтэй байсан 5 сургуульд шаардлага өгч зөрчлийг засуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд 14 их дээд, ерөнхий боловсролын сургуулийн 2160 сурагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажилласан.

г. ЦЕГ-с зохион байгуулсан “Яараад яахав дээ” аяны хүрээнд хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчидтай хамтран ажиллаж, идэвхи санаачилгатай ажилласан 1 алба хаагчийг Дүүргийн ГХУСАЗСЗ-с шагнаж, урамшуулсан.

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар 7, 8, 9 сард ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвтэй хамтран 3 удаа мэдээ бэлтгэн 8 телевизээр олон нийтэд түгээн ажилласан.

Хүүхдийн албаны 70 жилийн ойн баярын арга хэмжээнд зориулан бэлтгэж байгаа баримтат кинонд харъяа нутаг дэвсгэрийн Тэмүүжин өрлөг дунд сургууль, 128-р цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулан ажилласан.

### ***Насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн хэрэг, зөрчлийн талаар / тоот мэдээ, шийдвэрлэлтийн байдал/***

Тус хэлтэст 2019 оны эхний 08 сарын байдлаар **насанд хүрээгүй этгээдээс 25 гэмт хэрэг** үйлдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад **-21,9** хувиар өссөн.

#### **2.4 Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр**

***Бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн талаар хариуцсан нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн тоо мэдээ, түүний шийдвэрлэлт, хэргийн илрүүлэлтийг урьд онтой харьцуулсан байх, гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч үйдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүнг тооцсон байдал, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ***

***Бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн талаар хариуцсан нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн тоо мэдээ, түүний шийдвэрлэлт, хэргийн илрүүлэлтийг урьд онтой харьцуулсан байх, гэмт хэргийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч үйдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүнг тооцсон байдал, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ***



2019 оны эхний 09 сарын байдлаар иргэн, байгууллага, аж ахуй нэгжээс нийт 9184 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасаны 3174 буюу 34,6 хувь нь гэмт хэргийн, 6010 буюу 65,4 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Урд оны мөн үетэй харьцуулахад 31,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн хугацаанд бүртгэгдсэн 1652 хэргийн 1617 нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй ба 353 хэргийн сэжигтэнд ял сонсгож хэргийн илрүүлэлт **21,8** хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад **1,9** хувиар өссөн байна.

-Дүүргийн Прокурорын газартай хамтран сар бүр буюу 2019 оны 2 дугаар улирлын байдлаар 3 удаагийн уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнд давхардсан тоогоор 11 прокурор, 120 эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэсгийн байцаагч нар хамрагдаж, эрүү, зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой алдаа, зөрчлийг шийдвэрлэх, хамтын ажиллагааг сайжруулах талаар хэлэлцэж хэвшсэн.

Уулзалт зөвлөгөөнүүдээс гарсан шийдвэрийн дагуу Дүүргийн Прокурорын газар, хэлтсийн даргын 2019 оны 05 дугаар сарын 06-ны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/18, А/27 дугаар хамтарсан тушаалаар 5 эрүүгийн мөрдөгч, мөрдөгч нарын бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулж ажиллуулсанаар 05 дугаар сарын 06-31-ний өдрийн хооронд шүүхэд 16, харьяаллаар 5, хаасан 22, нэгтгэсэн 1, нийт 44 эрүүгийн хэргийг тус тус шилжүүлж шийдвэрлэсэн байна.

- 2017, 2018 онд гудамж талбай олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгаан дээр үндэслэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэлтсийн даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/04 тоот “Мэдэгдэл-Хяналт шалгалт” ерөнхий арга хэмжээг зохион байгуулах тухай тушаалын хүрээнд мэдэгдэл өгч, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг 87 аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж, мэдэгдлийн хариуг хугацаанд нь өгөөгүй, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй 17 аж ахуйн нэгж байгууллага, 11 иргэнд, мөн зохих зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан 6 барьцаалан зээлдүүлэх газарт нийт 34 зөрчилд 31.100.000 төгрөг, диско баар, ресторан, паб, кафе зориулалтаар үйлчилгээ явуулдаг 142 аж ахуйн нэгж байгууллагыг шалгаж, мэдэгдлийн хариуг хугацаанд нь өгөөгүй, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийт 56 зөрчилд 24.550.000 төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулсан.

Дээрх ажил, арга хэмжээг зохион явуулсанаар 2019 оны эхний 5 сарын байдлаар **1131 гэмт хэрэг** бүртгэгдсэнийг урд оны мөн үетэй харьцуулахад 440 буюу **-33,5** хувиар **буурч**, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг цэг салбарт мэдэгдэл өгч, хяналтыг сайжруулснаар **согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25,5** хувиар, **гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 47,9** хувиар тус тус **буурсан** үзүүлэлттэй байна.

#### ***Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлтийн чиглэлээр хийсэн ажлын талаар***

Гэмт хэргийн улмаас 2019 оны эхний 8 сары нбайдлаар 1496 иргэн хохирч, үүнээс 28 хүн нас барж, 361 хүн гэмтсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 24274,2 /сая төгрөгөөр/ төгрөгийн хохирол учирч 692,7 /сая төгрөгөөр/ буюу 2,9 хувийг нөхөн төлүүлжээ.

#### ***Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлагын мөрөөр зохион байгуулсан ажил шалтгаан нөхцөлийг тогтоох хариуцлага тооцох хариу хүргүүлсэн байдал хамтран сургалт зөвлөгөөн зохион байгуулсан ажил.***

2019 оны 3 дугаар улиралд Баянзүрх дүүргийн Прокурорын газраас “Прокурорын шаардлага” 1-ийг авч, шаардлагад 1 алба хаагч зөрчил заагдсан.

2019 онд Прокуророос ирүүлсэн шаардлага бүрээр алба хаагч нарыг дахин зөрчил гаргахгүй байх чиглэлээр алдаан дээр суралцах, бусад алба хаагчдад сургамж болох зорилгоор сургалтын материал бэлтгэн нийт мөрдөгч нарт сургалтыг зөрчил гаргасан алба хаагчаар оруулсан.

Мөрдөн байцаах тасгийн хэмжээнд хугацаа сунгасан, шүүх, прокуророос буцсан, ялангуяа удааширч байгаа шийдвэрлэгдэхгүй хэргүүдийг Дүүргийн прокурорын газрын

орлогч болон ахлах прокуроруудад танилцуулан хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхэд анхаарч даргын даалгавар бичиж зааварчлах, ахлах мөрдөгч, мөрдөгчийн ажлын хэсэг томилж удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласнаар тус тасаг нь ажлын үзүүлэлтээрээ албаны хэмжээнд 1, 2 дугаар сард ажлаараа тэргүүлсэн. Мөн 1 мөрдөгч 80-90 хэрэг гар дээрээ шалгаж байсан бол 45-50 хэрэг болж ажлын ачаалал 25-30 хувь буурсан. Удаашран шалгаж байсан 17 хэрэг байснаас 17 хэргийг шийдвэрлэсэн.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Прокурорын шаардлага”-ын тоо -3 нэгжээр буюу -75 хувиар, шаардлагад зөрчил заагдсан алба хаагч -18 нэгжээр -94 хувиар тус тус буурсан.

***Эрэн сурвалжлагдаж байгаа хүн оргодол цогцос, мал, эд зүйлийг илрүүлэх, олж тогтоох чиглэлээр***

Тайлангын хугацаанд нийт 103 хүн зарлагдсанаас, оргодол 13, зарлагдсанаас 8, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 140 зарлагдсанаас 66 этгээдийг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон. Хэлтсийн хэмжээнд 5 оргодол, 74 гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд эрэн сурвалжлагдаж байна.

“АСАП” санд эрэн сурвалжлалт зарласан 23 тээврийн хэрэгслийг хэрэг, гомдол мэдээлэл бүртэй тулгалт хийж, 19 тээврийн хэрэгслийн эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Эрэн сурвалжлалтын гүйцэтгэлийн хувийг 2019 оны нэгдүгээр улиралтай харьцуулахад гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд **76.3** хувиас **86** хувь, тээврийн хэрэгсэл 42.8 хувиас 91.8 хувь, шүүхээс даалгасан бусад хүн 31.2 хувиас 61.6 хувь, эд зүйлс 2.2 хувиас 64.9 хувь, хэлтсийн нийт эрэн сурвалжлалтын **гүйцэтгэл 35.7** хувиас **73.2 хувь болж өссөн эерэг үр дүнтэй байна**

***Мал хулгайлах болон анхаарал татсан зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар***

Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мал нядалгааны газар байхгүй ба Нарантуул зах болон мах, махан бүтээгдэхүүн зарж борлуулдаг худалдааны 10 төвүүдэд хяналт шалгалт хийж, хяналтын камер, бүртгэл судалгаатай болгох чиглэлээр албан мэдэгдэл өгч, биелэлтийг тооцоны ажилласан.

Тайлангийн хугацаанд мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй.

***Эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө битүүмжлэх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил***

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нуугдмал эд хөрөнгө илрүүлээгүй. Эрүүгийн болон зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 15.000.000 төгрөгний хөрөнгө битүүмжилсэн.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨЛӨВЛӨЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ  
ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН АХМАД

Г.БУЙРЦЭНГЭГ

ХЯНАСАН:

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.АРИУНЖАРГАЛ